# БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН КАРТ - № 2024/2683

| | | |
|---|---|---|
| **Баримт бичгийн нэр төрөл**<br>МУ-ын хэмжээнд | **Хаанаас, хэнээс**<br>Сангийн яам | **Хаана, хэнд** |
| **Баримт бичгийг хүлээж авсан огноо**<br>4/3/2024 | **Баримт бичгийн огноо**<br>4/2/2024 | **Баримт бичгийн дугаар**<br>03/2094 |
| **Баримт бичгийн гарчиг /товч утга/**<br>Тендер шалгаруулалтыг түдгэлзүүлэх тухай | | **Баримт бичгийн хуудасны тоо**<br>2 |

Удирдлагын заалт /тайлбартай/: ☐ Яаралтай

Баримт бичгийн шийдвэрлэх эцсийн хугацаа: _____ он _____ сар _____ өдөр

Албан тоотыг хариуцаж, хариу хүргүүлэх газар, хэлтэс, алба: ______________________________

Хаана хэнд хүргүүлсэн:

| | |
|---|---|
| ☐ - Гүйцэтгэх захирал | ☐ - Салбарын удирдлагын газар |
| ☐ - Тэргүүн дэд захирал | ☐ - Маркетинг, олон нийттэй харилцах газар |
| ☐ - Дэд захирал | ☐ - Даатгалын газар |
| ☐ - Засаглалын алба | ☐ - Аж ахуй, Аюулгүй байдлын газар |
| ☐ - Дотоод аудитын газар | ☐ - Комплаенсийн газар |
| ☐ - Дотоод хяналт, шалгалтын газар | ☐ - Харилцагчийн үйлчилгээний газар |
| ☐ - Санхүүгийн газар | ☑ - Үйл ажиллагааны газар |
| ☐ - Эрсдэлийн удирдлагын газар | ☐ - Байгууллагын банкны зээлийн судалгааны хэлтэс |
| ☐ - Бизнесийн бодлого, төлөвлөлтийн газар | ☐ - Иргэдийн банкны зээлийн судалгааны хэлтэс |
| ☐ - Хүний нөөцийн газар | ☐ - Зээлийн хэрэг бүртгэлийн хэлтэс |
| ☐ - Зээлийн газар | ☐ - Карт, АТМ, цахим банкны үйл ажиллагааны хэлтэс |
| ☐ - Хуулийн газар | ☐ - Мэдээллийн аюулгүй байдлын алба |
| ☐ - Хөрөнгө зохицуулалтын газар | |
| ☐ - Мэдээллийн технологийн газар | |

Дараах арга хэмжээг авах тухай:

| | |
|---|---|
| ☑ - Арга хэмжээ авах | ☐ - Мэдээлэл хүргүүлэх |
| ☐ - Судлаад гүйцэтгэх захиралд санал өгөх | ☐ - Бусад |

Хариуөгсөн огноо 2024.04.05

Гарын үсэг [signature]

© 2024 - ТӨРИЙН БАНК. Албан хэрэг хөтлөлт, архивын программ

ТӨРИЙН БАНКАНД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ
Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.04.02 № 03/2093

танай ____________-ны №____________ -т

Тендер шалгаруулалтыг
түдгэлзүүлэх тухай

Танай байгууллагаас зарласан ТБ/20240101003 дугаартай “Баян-Өлгий аймаг - Цэнгэл тооцооны төвийн барилга угсралтын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Өлке констракшн” ХХК, мөн ТБ/20240202118 дугаартай “Ханшийн самбар” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Эм Ди даян” ХХК-аас тус тус Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна.

Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
2. Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр;
3. Батлагдсан тендер шалгаруулалтын баримт бичиг;
4. Оролцогчдын ирүүлсэн тендер /Тендер нээх нууц үг/;
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл;
6. Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл;
7. Оролцогч болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
8. Гэрээ байгуулах эрх олгох, шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр;
9. Захиалагч гомдол хянан шийдвэрлэсэн бол холбогдох шийдвэр;
10. Холбогдох бусад баримт бичиг.

Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9 дэх хэсэгт заасны дагуу оролцогч нарт энэхүү шийдвэрийг мэдэгдэх, журмын 5.2-т заасны дагуу гомдол гаргагчийн тендерийн баталгааг чөлөөлөхгүй байхыг анхаарна уу.

4/3-ний 16⁰⁰ цагт ирэв.

9766003557

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

Хувийг: Баян-Өлгийн аймгийн Худалдан авах ажиллагааны газарт.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ж.ГАНБАТ